**“ХОРГО ХАЙРХАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2019 оны 04-р сарын 25-ны өдөр № 1 Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж байгаа Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Тооллогын комисст ирүүлсэн “ҮЦТХТ” ХХК-ийн 2019 оны 04-р сарын 09-ны өдрөөр тасалбар болгон гаргасан “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа болон Үнэт цаас эзэмшигчийн тодорхойлолтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд **110,018** ширхэг хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа болох **135,126.00₮** ширхэг энгийн хувьцааны **81,42%** болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн 7.1.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны **81,42%-**ийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА** **Э.ТӨГӨЛДӨР**

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН** **Д.САЙНБАЯР**

## ТООЛЛОГЫН КОММИССЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР

2019 оны 04-р сарын 25-ны өдөр №3 Улаанбаатар хот

"Хорго Хайрхан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарласан "Хорго Хайрхан" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр ээлжит хурлыг хуралдуулах шийдвэрт заасны дагуу Э.Төгөлдөр миний бие "Хорго Хайрхан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар ажил гүйцэтгэв.

Тооллогын комиссын бүрэлдэхүүнд ажилласан Д.Сайнбаяр нарын иргэний үнэмлэхний хуулбарыг Хорго Хайрхан ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч З.Маралмаад хүлээлгэн өгөхөөр хавсаргав.

Тооллогын комиссын дарга: Э.Төгөлдөр
Тооллогын комиссын гишүүн: Д.Сайнбаяр

2019 оны 04 дугаар сарын 25-ны "Хорго Хайрхан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй **135,126** ширхэг энгийн хувьцааны **110,018** ширхэг хувьцаа эзэмшдэг буюу нийт саналын эрхтэй хувьцааны 81,42 хувийг төлөөлсөн 2 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн. Дараах хувьцаа эзэмшигчид хуралд ирсэн:

| | **Хувьцаа эзэмшигчдийн нэрс** | **Тоо/ш** | **Эзлэх хувь** |
|---|---|---|---|
| | | **Ирц** | |
| 1 | "Монгол Даатгал" ХХК | 109,921 | 81,35% |
| 2 | "Би Ди Сек" ХХК | 97 | 0,07% |
| | **Нийт** | **110,018** | **81,42%** |

Үүнээс доорх 1 хувьцаа эзэмшигч нар итгэмжлэгдсэн төлөөлөгчтэйгээр хуралд оролцсон:

1. "Би Ди Сек" ХХК-иас Өнөрбаян /РД:ОР97022009/

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын хуудас, итгэмжлэл / ширхэг/ зэргийг "Хорго Хайрхан" ХК-ийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч З.Маралмаад хүлээлгэн өгөхөөр хавсаргав.

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА** **Э.ТӨГӨЛДӨР**

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН** **Д.САЙНБАЯР**

# “ХОРГО ХАЙРХАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр | № 1 | Улаанбаатар хот

**Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх зүйл, “Хорго Хайрхан” ХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2018 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АЮУШ

**“ХОРГО ХАЙРХАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2019 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр

№ 2

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх зүйл, “Хорго Хайрхан” ХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 3 дугаар тогтоолыг үндсэлэн ТОГТООХ НЬ:

1. Дараах нэр бүхий хүмүүсиг компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:

1.Ц.Мөнхбат
2. М.Сугир
3. Д. Мөнхбат
4. М. Чингүүн
5. Р.Энхбаяр
6.Ч.Энх-Амгалан нарыг;

2. Дараах нэр бүхий хүмүүсийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай:

1.Огай Наталья
2. Б. Аюуш
3. Б.Жамбал нарыг тус тус сонгосугай

3. Хууль болон Компанийн дүрмээр тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө мэдлэг чадвараа дайчлан ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АЮУШ

# “ХОРГО ХАЙРХАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр

№ 3

Улаанбаатар хот

***Зарим шийдвэрийг дахин баталгаажуулах тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх зүйл, “Хорго Хайрхан” ХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанид Монгол даатгал ХХК-ийг нэгтгэх шийдвэртэй холбогдуулан 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дараах шийдвэрийг дахин баталгаажуулсугай:

   1.1. Компанийн зарласан хувьцааны тоог өөрчлөн тогтоосон дүрмийн шинэчлэсэн найруулгыг батлах

   1.2. Өөрчлөн байгуулсантай холбогдон хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам батлах

ХУРЛЫН ДАРГА Б.АЮУШ

# “ХОРГО ХАЙРХАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр | № 4 | Улаанбаатар хот

***Компанид Монгол даатгал ХХК-ийг нэгтгэх гэрээ, журмыг батлах , зарласан хувьцааны тоог шинэчлэн тогтоох тухай***

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн заалтууд, “Хорго Хайрхан” ХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанид Монгол даатгал ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрч, нэгтгэх гэрээ болон нэгтгэх журмыг хавсралт 1 болон Хавсралт 2-оор тус тус баталсугай.
2. Нэгдэж буй Монгол Даатгал ХХК-ийн оноосон нэрийг өөрчлөн байгуулагдсан компанид үргэлжлүүлэн хэрэглэхийг зөвшөөрсүгэй.
3. Компанид Монгол даатгал ХХК-ийг нэгтгэж байгаатай холбогдон хөрвөж байгаа нийт 63,997,215 ширхэг хувьцаагаар компанийн зарласан хувьцаа болон хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсүгэй.
4. Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг хангахын тулд 15,923 173 ширхэг хувьцаа нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тогтоолын 3 болон 4 дэх заалтыг үндэслэн компанийн зарласан хувьцааны тоог 80,089,296 ширхгээр тогтоосугай.
6. Компанид Монгол даатгал ХХК-г нэгтгэх ажиллагааг журам болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэх, нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдаж авах давуу эрхийг хэрэгжүүлэх, Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авах, өөрчлөн байгуулалтыг Улсын бүртгэлд бүртгүүлэх ажиллагааг зохион байгуулахыг ТУЗ /Ц.Мөнхбат/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АЮУШ

**"ХОРГО ХАЙРХАН" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр

№ 5.

Улаанбаатар хот

**Санал хураасан дүнгийн тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн заалтууд, "Хорго Хайрхан" ХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Санал хураах хуудсыг тоолсон дүнг тус тус үндэслэн үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Компанийн 2018 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байна:
   - зөвшөөрсөн 110018 санал, зөвшөөрөөгүй байхгүй, нийт оролцогсдын 100 хувийн саналаар баталсан
2. Компанид Монгол даатгал ХХК-г нэгтгэх гэрээ, журмыг батлах тухай асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байна:
   - зөвшөөрсөн 110018 санал, зөвшөөрөөгүй байхгүй, нийт оролцогсдын 100 хувийн саналаар баталсан
3. Компанийн дүрмийн шинэчлэсэн найруулгыг батлах тухай асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байна:
   - зөвшөөрсөн 110018 санал, зөвшөөрөөгүй байхгүй, нийт оролцогчдын 100 хувийн саналаар баталсан
4. Компанид Монгол даатгал ХХК-ийг нэгтгэж байгаатай холбогдон зарласан хувьцааны тоог хөрвөж байгаа нийт 63,997,215 ширхэг хувьцаагаар нэмэгдүүлэх, МХБ-ийн шалгуурыг хангахын тулд нэмж гаргах хувьцааны тоог 15,923 173 ширхгээр, нийт нэмж гаргах хувьцааны тоог 79,920 388 ширхэгээр тогтоох асуудлаар санал хураасан дүн:
   - зөвшөөрсөн 110018 санал, зөвшөөрөөгүй байхгүй, нийт оролцогчдын 100 хувийн саналаар баталсан
5. Компанийн 2018 оны ээлжит хурлын зарим шийдвэрийг баталгаажуулах , үүний дотор компанийн дүрмийн шинэчлэсэн найруулгад зарласан хувьцааны өөрчлөлтийг тусган батлах, хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журмыг батлах асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байна:
   - зөвшөөрсөн 110018 санал, зөвшөөрөөгүй байхгүй, нийт оролцогчдын 100 хувийн саналаар баталсан

КОМИССЫН ДАРГА Э.ТӨГӨЛДӨР